



ХЭНТИЙ АЙМГИЙН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2024.04.02 № 03/2144
танай _____-ны № _____-т

Гомдол хянасан тухай

Танай байгууллагаас зарласан ХЭАЭМГ/20240102001 дугаартай “Хэнтий аймгийн сумдын ЭМБ, УАУНЭ-ийн эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах” нийлүүлэгчийг сонгох тендер шалгаруулалтын 12 дугаар багцад оролцсон “Монос трейд” ХХК-аас гаргасан гомдлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 59 дүгээр зүйлийн 59.8 дахь хэсэг болон Сангийн сайдын 2023 оны А/253 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-д заасны дагуу захиалагчаас ирүүлсэн холбогдох баримт материалд үндэслэн хянан үзлээ.

“Монос трейд” ХХК-ийн гомдолд захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон “Мөнхийн тун” ХХК-ийн нийлүүлэхээр санал болгосон тариурыг үйлдвэрлэгч “Мон тариур” ХХК-аас “Мөнхийн тун” ХХК-д олгосон итгэмжлэлийн хугацаа нь дууссан байхад тус компанийг шаардлагад нийцсэн гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэрийг хянан өгөхийг хүссэн байна.

Гомдолд дурдсаны дагуу захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон “Мөнхийн тун” ХХК-ийн ирүүлсэн тендерийг хянан үзлээ.

“Мөнхийн тун” ХХК тендерт “Мон тариур” ХХК-тай байгуулсан 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 22/042 дугаартай худалдах, худалдан авах гэрээг ирүүлсэн байна. Тус гэрээний хүчин төгөлдөр үйлчлэх хугацаа нь 1 жил гэж гэрээний 2.1.b-д, гэрээ 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдөр дуусгавар болно гэж гэрээний 2.1.c-д тус тус заасан байх боловч гэрээний 2.2-т “Энэхүү гэрээний 2.1-ийн “с” дэх хэсэгт заасан хугацаа дуусгавар болсон боловч талууд гэрээг цуцлах санал гаргаагүй бол тус зүйлийн “b” дэх хэсгээр тохиролцсон хугацаагаар дахин нэг удаа сунгагдсан тооцно” гэж заасан байна.

Иймд дээрх гэрээг талууд сунгасан эсэхийг нийлүүлэгч “Мон тариур” ХХК-аас нягтлан тодруулж, Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-ын 5.9-д “Сангийн яам гомдол хянан шийдвэрлэхэд хуулийн 59.10-т зааснаар хууль зөрчсөн гэж үзэх үндэслэл тогтоогдоогүй асуудлаар захиалагчийг хуулийн 48.2.3-т заасан эрх, үүргийн хүрээнд хяналт тавихыг даалгасан бол захиалагч хуулийн 28.1-д зааснаар шийдвэр дахин гаргах эсэхийг шийдвэрлэж, оролцогчид мэдэгдэнэ.” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй байна.

9766003648

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсэгт заасны дагуу захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг түдгэлзүүлсэн шийдвэрийн хугацаа үүгээр дуусгавар болно.

Хувийг: "Монос трейд" ХХК-д.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



Ж.ГАНБАТ